

ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Холбоо барих утас: 1800-1646, 7575-1111 /1376/
Цахим шуудан: investornews@golombank.com



“ГОЛОМТ БАНК” ХК-ИЙН 2025 ОНЫ 3-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН НИЙТЛЭГДЛЭЭ

2025 оны эхний хагас жилийн банкны салбарын үзүүлэлтүүдийг танилцуулж байна.

Банкны салбарын голлох статистик үзүүлэлтүүд:

- Банкны салбарын нийт зээл 2025 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27%-аар өсөж, 42.2 их наяд төгрөгт хүрлээ. Нийт зээлийн 4.2% буюу 1.7 их наяд төгрөг нь анхаарал хандуулах зээл байна.
- 2024 оны эцэст чанаргүй зээлийн хэмжээ 5%-д хүрсэн нь сүүлийн 15 жилийн хамгийн доод түвшиндээ хүрсэн. 2025 оны эхний хагас жилд нийт зээлийн багцын 4.9% нь чанаргүй зээл байна.
- Корпорейт зээл өмнөх оны мөн үеэс 3.4 их наяд төгрөг буюу 25.5 хувиар, өмнөх сараас 1,292.5 тэрбум төгрөг буюу 8.5 хувиар өсөж, 16.5 их наяд төгрөгт хүрчээ.
- Иргэдийн зээл өмнөх оны мөн үеэс 5.2 их наяд төгрөг буюу 26.7 хувиар, өмнөх сараас 558.4 тэрбум төгрөгөөр буюу 2.3 хувиар өсөж, 24.6 их наяд төгрөгт хүрэв.
- ЖДБ зээл банкнуудын нийт зээлийн 22.7 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 28.2 хувиар өсөж, 9.6 их наяд төгрөгт хүрчээ.
- Ипотекийн зээл 2025 оны 6 дугаар сарын байдлаар 127,046 зээлдэгчийн нийт 10.4 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 21.2 хувиар өсжээ.
- 2025 оны 6 дугаар сард шинээр татсан төгрөгийн хадгаламж болон шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүгийн зөрүү 5.7 нэгж хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар буурсан бол өмнөх сараас 0.4 нэгж хувиар өссөн.

Голомт банкны 2025 оны 3-р улирлын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад :

- Банкны нийт актив 3.1 их наяд төгрөг буюу 24.8%-аар өсөж, 15.6 их наяд төгрөгт хүрлээ.
- Нийт өөрийн хөрөнгө 254 тэрбум буюу 21%-аар өсөж, 1.5 их наяд төгрөгт хүрэв.
- Нийт зээлийн багцаа 10.4%-аар тэлж, 7.8 их наяд төгрөгт хүргэв. Зээлийн багцын тэнцвэртэй байдлыг хангаж ажилласнаар 55%-ийг байгууллагын зээл, 45%-ийг иргэдийн зээл бүрдүүлж байна. Чанаргүй зээлийн харьцаа 3.2%-д хүрэв.
- Харилцагчийн эх үүсвэр 1.6 их наяд төгрөг буюу 21%-аар өсөж, 9.1 их наяд төгрөгт хүрлээ. Хөрөнгө оруулалтын багц 43.4%-аар өсөж, 1.5 их наяд төгрөгт хүрэв.
- Татварын дараах цэвэр ашиг 251.3 тэрбум төгрөгт хүрч жилээр илэрхийлсэн дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 24.1%-д хүрлээ.
- Монголбанк болон Олон Улсын санхүүгийн байгууллагуудаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.

Хөрөнгө оруулагчдадаа зориулан Голомт банкны удирдлагууд сүүлийн тайлант жилийн санхүүгийн үр дүн болон цаашдын төлөвийн талаар хэлэлцэх “Earnings call” болон асуулт, хариултын (Q&A) шууд дамжуулалтыг өөрсдийн сувгаар 2025 оны 10-р сарын 24-ний өдөр 16:00 цагт зохион байгуулна.

“Голомт банк” ХК компани 2025 оны 3-р улирлын санхүүгийн тайлангаа Хөрөнгө оруулагчдын харилцааны вэбсайтаа байршуулан нийтэллээ.

Тайлантай танилцахыг хүсвэл [ЭНД](#) дарж зочилно уу.

Банкны тухай нэмэлт мэдээллийг дараах сувгуудаар авах боломжтой www.golombank.com/investor-relations

| X: [@golombank](#) | LinkedIn: www.linkedin.com/company/golombank

| YouTube: www.youtube.com/golombank

| Facebook: www.facebook.com/Golombank